



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 06 өдөр

Дугаар А/78

Номгон

Г Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой Г
төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж,
зөвлөмж боловсруулах ажлын хэсэг
байгуулах тухай

Монгол Улсын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2022 оны А/286 дугаар захирамжаар батлагдсан “Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын 6.1, 6.2, 6.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг үнэлж, зөвлөмж боловсруулах байнгын ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга

Гишүүд: Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Өргөдөл, гомдол, дотоод ажил хариуцсан ахлах мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Мэдээлэл технологи хариуцсан ажилтан

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Байгаль орчин, аялал жуулчлал, газрын харилцаа, уул уурхайн бодлого хариуцсан мэргэжилтэн

Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн Хэвлэл, олон нийттэй харилцах ажилтан

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Орчны бохирдлын асуудал хариуцсан мэргэжилтэн

Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Ой, ургамал, цөлжилтийн асуудал хариуцсан мэргэжилтэн


642310185

2.

Нарийн бичгийн дарга: Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

2.Сум, агентлаг, орон нутгийн өмчит байгууллагын Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд холбогдох журмын дагуу хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж гарсан дүн, ахиц өөрчлөлт, цаашид авах арга хэмжээний талаар зөвлөмж боловсруулж, Засаг даргын удирдлагын багт тухай бүр танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн дарга)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН